

Эртний Дорно дахины ёс
зүйн сургаал

Эртний хятадын ёс зүйн сургаал

- Эртний хятадын ёс зүйн сургаал олон мянган жилийн түүхтэй.
- Гол төлөөлөгч нь Күнз
- Түүний ёс суртахууны сургаал нь 2000 гаран жилийн түүхтэй.
- Жоу угсааны хаанчлалын үед төрсөн.



Амьдралын тухай

- Хятадын түүхэнд анхны хувийн сургуулийг байгуулсан бөгөөд түүнийг өндөр албан тушаалд урьж байсан ч тэрээр шавь нараа дагуулан аялахыг илүүд үзэж, бусдыг сайн сайханд уриалан Хятад орноор 14 жил аялжээ.
- МЭӨ 483 онд 68 насандаа төрсөн нутагтаа ирж, хэдэн хэдэн бүтээл туурвисан нь эдүгээд хүрчээ.
- Түүний амьдарч байсан гэрийг сүм болгон өнөөдөр ч гэсэн хүмүүс очдог ариун шүтээний газар болжээ.

Күнз өөрийн амьдарч байсан төрийг:



Удирдагч хүн ямар байх вэ?



Хүнлэг ёс – түүний хамгийн алдартай үзэл санаа

- Хүний амьдрал ахуйн үндэс нь ёс суртахуун. Ялангуяа хүнлэг ёс юм.
- Хүнийг хүн болгож, бусдаас ялгаж байдаг зүйл бол хүнлэг ёс. Өөрийн ажил, амьдралын бүхий л шатанд хүнлэг ёсыг эрхэм болгох.
- Хүнлэг ёс хүний оршихуйн шалтгаан. Хүн амьдралдаа янз бүрийн зам гаргаж болно. Гэвч хүнлэг ёсны замаас хазайж хэрхэвч болохгүй.
- Хүнлэг ёс – хүний гол зам мөр, гол удирдлага.

Хүний амьдрал янз бүр байдгийн шалтгаан юу вэ?

Күнзийнхээр хүнлэг ёсын хэрхэн биелүүлснээс хүний аж амьдрал янз бүр байдаг. Хүнлэг ёсны эхлэл нь гэр бүл. Эцэг эхийн үлгэр дууриалал



Хүний эзэмшвэл зохих 2 зүйл


1. Хүнлэг ёс
2. Соёл

- Хүнлэг ёсыг эзэмшсэнээр хүнийг хайрлагч хүн болно. Кантынхаар хүнийг хэрэгсэл болгодоггүй хүн болно.
- Хүнлэг ёсонд тэмүүлж буй хүн муу үйлийг үйлддэггүй.
- Хүнлэг хүн амар тайван амьдарч, мөнхөд алдарших нөхцөлийг бүрдүүлсэн байдаг гэсэн санааг дэвшүүлсэн.
- Ийнхүү ёс суртахууны үндсийг хүнлэг ёс хэмээн үзэж, нийгэм, улс төр, эдийн засгийн асуудлыг шийдвэрлэх гол түлхүүр болохыг онцолсон.

Хүний эрхэмлэх болон цээрлэх зүйлийг заажээ.

Эрхэм хүний цээрлэх 3 зүйл

1. Бие гүйцээгүй насанд дурлал цэнгэлийг
2. Хүч чадалтай идэр насанд догшин араншинг
3. Бие махбод суларсан өтөл насанд шуналыг



Эрхэм хүн 3 зүйлийг цээрлэнэ.

- 1. Хүнийг муулсан хүн
 - 2. Шийдэмгий атлаа бодлогогүй хөдөлдөг
 - 3. Зоригтой мөртлөө ёс горимыг баримталдаггүй
- Ёс горимгүй хүндэтгэл бужигнаан болдог.
 - Ёс горимгүй болгоомжлол айдас болдог.
 - Ёс горимгүй зориг самуун болдог.
 - Ёс горимгүй шулуун зан бүдүүлэг болдог.

Күнзийн сургаал дахь ёс зүйн ойлголтууд

Ли буюу ёс горим

- Хүний амьдралын мөрийн хөтөлбөр
- Хүмүүс хоорондын эв найрамдлын үндэс

Жэнь буюу хүнлэг ёс

- Тайван амьдралын үндэс
- Бусдад тус хүргэх

Синь буюу үнэнч шударга


- Шударга хүнд хүмүүс итгэдэг
- Их хий, бага ярь

И буюу үүрэг хариуцлага

Хүлээсэн үүргээ биелүүлэх. Эцэг нь эцэг шиг,
хүү нь хүү шиг. Багш нь багш шиг шавь нь
шавь шиг

Биеэ авч явахад баримтлах зарчим

- Хурц харах /зөвийг тусгадаг байх/
- Тод сонсох /Зөв ойлгож сонсох/
- Элэгсэг байх
- Бусдад хүндэтгэлтэй хандах
- Чин сэтгэлээсээ ярьдаг байх
- Хянуур байх
- Шударга байх
- Уур хилэнгийн үр дагаврыг байнга санах
- Ажилд чин сэтгэлээсээ хандах



Эдгээрийг мөрдөж чадвал
эрхэм хүмүүний амьдралаар
амьдарч чадна

Хүний амьдралыг харанхуй болгодог
зүйлс:

Өнгөнд шунах

Зоосонд шунах

Архинд шунах

- Эртний энэтхэгийн ёс зүйн сургаал: Буддизм

Гол ойлголтууд

- Зовлон
- Үйлийн үр
- Буян, нүгэл
- Хоосон чанар
- Хутагтын 4 үнэн
- 8 мөчирт сургаал
- Энэрэл нигүүлсэл
- Тэвчээр гэх мэт

Амьдрал зовлонгоор дүүрэн.
Бусдын амьдралын зовлонгийн шалтгаан
болохгүй байх нь хүний амьдралыг утга
учиртай болгоно.

Бүх зүйлийн шалтаан нь
өөрөө.

Үйлийн үр хэмээх ойлголт

- Өнөөдөр бидэнд бие, сэтгэл хоёулантай нь холбогдсон мэдлэг бидэнд зайлшгүй хэрэгтэй байгаа юм. Хүн төрөлхтөн бидэнд тулгамдаж буй бэрхшээл нь хоёр төрөлтэй байна. Үүнд: 1. Хүний үүсгэсэн бэрхшээл 2. Байгалийн жамаар үүдсэн бэрхшээл болно.
- * Үйлийн үрийн тухай онолыг ойлгочихвол бэрхшээл үүсгэдэг хүмүүсийн тоо багасах юм.
- Хүн амьдарч л байгаа бол үйл үйлдэж, үр дагаврыг бий болгож, биеийн, хэлний, сэтгэлийн үйлийг ямагт үйлдэж байдаг. Өнөөгийн нийгэмд мэдлэгээр ихэд хоосорсон зүйлгүй ч хүний зарим үйлдэл аюул заналыг дагуулсаар байна.
 - Ялгаварлан гадуурхах, атаархах, уур, шунал тачаалдаа баригдах, хулгай хийх, худал хэлэх, улс орноо тонон дээрэмдэх явдал ихэссэн нь бидний оюун санаа цаанаа энэрэл хайр, тэсвэр тэвчээр, сэрэмж, билгүүн тэргүүтнээр хоосорсныг илтгэнэ. Ийм учраас хүний үйлдсэн муу үйлийн шалтгааныг арилгах, түүнийг ойлгуулахын тулд үйлийн үрийн тухай

- **Үйлийн үр:** Хүний амьдралын жаргал зовлон гэдэг бол бидний хийсэн үйлээс л үүдэлтэй. Сайн үйл хийвэл сайн үр дүн, муу үйл хийвэл муу үр дүн бий болно. Ингэхлээр үйлийн үр нь бидний түгээмэл ойлгодог дан ганц сөрөг утгыг илэрхийлдэггүй.
- **Үйл гарцаагүй:** Жаргал, зовлон гаднаас ирдэггүй. Харин бидний хийсэн үйлээс л бий болдог. Нэгэнт үйл хийсэн бол үр дагавар нь ирэх нь гарцаагүй. Та мөрөөдлийнхөө төлөө хичээн сурч байгаа бол үр дагавар нь нэгэнт ирнэ.
- “Өнөөгийн байдлаар дэлхийн 5 хүн тутмын 1 нь амьдралынхаа хугацаанд сэтгэцийн ямар нэг эмгэгт нэрвэгдэж байгаагаас гадна хөдөлмөрийн чадвар алдсан 2 тохиолдол бүрийн нэг нь сэтгэцийн эмгэг байна. Дэлхийн хэмжээнд 1998 онд бүртгэгдсэн нийт өвчлөлийн 11 хувийг сэтгэц, зан үйлийн эмгэг эзэлж байсан бол энэ нь 2020 онд 15 хувь болж нэмэгдэх магадлал байгаа тухай Дэлхийн эрүүл мэндийн байгууллага мэдээлсэн байна. Хөгжиж буй орнуудад халдварт болон эх, хүүхдийн өвчин, хоол тэжээлийн асуудал нь өвчлөл, нас баралтын гол шалтгаан болж байгаа хэдий ч сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал, сэтгэцийн эмгэг цаашид улам нэмэгдэх хандлагатай байгаа юм” гэжээ.
- Зөв зүйлийг бодож, ярьж, үйлдэж явах нь бэрхшээлтэй асуудлууд биднээс хол байх боломжтой юм.
- Бухимдал, стресс, уур уцаар, тэвчээргүй зан гэх мэтээс сэргийлэх арга зам нь сэтгэлээ зөв болгох явдал юм.

- *Үйл алга болдоггүй:* Хүний хийсэн сайн үйл ч, муу үйл ч алга болдоггүй. Тухайлбал, муу үйлийг үйлдээд бусад мэдэхгүй өнгөрчихлөө гэж баярлаж болдоггүй. Харин үүний оронд уучлал гуйж, түүнээс хойш тэр муу үйлээ дахиж үйлдэхгүй бол үйлийг эдлэхгүй өнгөрч болно.
- *Үйл нь хүнд, хөнгөн болох шалтгаан:* Миний аз жаргалын шалтгаан би өөрөө, зовлонгийн шалтгаан ч би өөрөө юм. Үйл хүнд, хөнгөн байх нь тухайн хүний гэмших сэтгэлээс хамаарна. Тухайлбал, дотнын хүндээ ширүүн үг хэллээ гэж бодоход үнэн сэтгэлээсээ гэмшиж, дахин тийм үг хэлж гомдоохгүй юм шүү гэж бодвол үйл хөнгөн болно. Харин хэлсэн ширүүн үгэндээ огт гэмшихгүй, тоохгүй байвал үйл хүнд болно.
- *Нөхцөл байдалд тохируулан хэрэгжүүлэх:* Хүний амьдрал баялаг учраас янз бүрийн зүйл тохиолдоно. Гарцаагүй тохиолдол, аргагүй нөхцөл байдлыг ялган таниулах шаардлагатай. Мөн нөхцөл байдалд тохируулан хэрэглэх нь тухайн хүнээс тэвчээр, санаачилга шаарддаг. Байгаа зүйлээ тордон хэрэглэх нь монголчуудынхаар арвич хямгач зан юм. Орчин үед минималист амьдралын хэв маяг гэж их ярих болжээ. Монголчууд угаасаа минималист амьдралтай байж ирсэн. Энэ нь байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой хэрэглэх, байгалийн баялгийг хишиг хэмээн залбирч хүртэх, хэрэглээнээсээ ихийг авдаггүй байсан зэрэг нь бидний нүүдлийн соёл иргэншлийн сайн жишээнүүдийн нэг юм.

Зан чанараараа хүн 4 хэсэгт хуваагддаг

Зовж шаналж буй хүмүүс

- Буруу зүйлд итгэж бие сэтгэлээ зовоогчид

Бусдыг зовоогч хүмүүс

- Амьтны амь
- Хулгай хийх

Өөрсдөө зовж, бусдыг зовоодог хүмүүс

- Буруу зүйлд итгэнэ
- Бусдад түүнээ тулгана

Өөрсдөө үл зовж, бусдыг үл зовоодог хүмүүс

- Амар амгалан амьдралын шалтгаан юунд оршдгийг мэднэ.

Энэ ертөнцөд 3 төрлийн хүмүүс байна.

Чулуун дээр
сийлсэн бичиг
лүгээ хүмүүс

- Уурлаж уцаарлах нь олон
- Байнга гомдох

Элсэн дээр зурсан
бичиг лүгээ хүмүүс

- Уурлаж уцаарлах нь их ч түргэн мартана

Усан дээр бичсэн
бичээс лүгээ
хүмүүс

- Муу муухайг сонсоод хов болгодоггүй, хэрэгсдэггүй
- Санаа сэтгэл нь мууг үл ойшоох

Хутагтын 4 үнэн

Зовлон
байдаг нь
үнэн

Зовлонгийн
шалтгаан
үнэн

Зовлонг
туулах нь
үнэн

Зовлонг
туулах арга
зам үнэн

8 мөчирт сургаал

- Зөв үзэл
- Зөв санаа
- Зөв үг
- Зөв үйл хэрэг
- Зөв амьжиргаа
- Зөв тэмүүлэл
- Зөв ой ухаан
- Зөв бясалгал

ЗӨВИЙГ СЭТГЭЛИЙГ ТӨРҮҮЛЭХ

- Зөв үйлийг хийж, зөв зүйлийг бодож явах нь хүний эрүүл мэндийг дэмжиж байдаг. Атаархал, буруу сэтгэл хүнийг өвчлүүлдэг. Зөв сэтгэлийг төрүүлэхэд хүний биеийн дархлаа сайжирдгийг анагаах ухааны эрдэмтэд тогтоосон.
- Зөв сэтгэлийг төрүүлэх их энгийн. Зөв сэтгэлийг төрүүлэнгүүт өөрөө аз жаргалтай болохоос гадна бусдад аз жаргалтай сайхан мэдрэмжийг өгдөг.
- Ууртай хүний хажууд хүн тайван байж чаддаггүй бол уужуу зөв сэтгэлтэй хүний хажууд бусад хүн жаргаж амьдардаг.
- Зөв сэтгэлийн үрээс зөв үйл гардаг. Жишээлбэл, бид хавар төмсний үр суулгаад намар хурааж авдаг. Харин төмсний үр суулгахад түүнээс жимс ургадаггүй шиг бидний хийж буй үйлдлээс түүнтэйгээ төстэй л үр дагавар гарна.
- Бидний хийж буй үйл, үйлдлээс үр дагавар нь түүнтэй төстэй л гарна гэсэн зүй тогтол юм.
- ТӨМС ТАРЬЧИХААД ЖИМС ХҮЛЭЭХ ХЭРЭГГҮЙ.

Даалгавар

Күнзийн аль эсвэл буддын ёс зүйн сургаалаар нэмж дэлгэрүүлэн уншиж, аль нэгийг нь сонгож Ппт бэлтгэх/тэмдэглэл хийх